

15. ЗӨГИЙН БАЛНЫ НЭМҮҮ ӨРТГИЙН СҮЛЖЭЭ



15-1. Баг болцгооё	237
15-2. Хамтрах аргаар ашгаа нэмэгдүүлэх	238

15-1. Баг болцгооё

Та бусадтай хамтрах тухай бодож байна уу? Зөгийн бал үйлдвэрлэх явцад ганцаараа хийж амжихгүй зарим зүйл дээр бусадтай хамтрах нь илүү ихийг хийх, шинэ зах зээлийг бий болгох зэрэг боломжууд нээгдэж магадгүй юм.

Танай аж ахуйд зөгийн бал бэлтгэгдээд улмаар бэлэн бүтээгдэхүүн бий болох үйл ажиллагаанд хэнтэй хамтарч байгаагаа бодож үзье.

 Материал бэлтгэх	Үүр хайрцагны мужаан, эм үйлдвэрлэгч, шил импортлогч, малын эмч г.м.
 Зөгийн аж ахуй	Зөгийчин найз, зөвлөгч багш, малын эмч г.м.
 Боловсруулалт, түгээлт	Савлах үйлдвэр, шинжилгээний байгууллага, хүнсний эрүүл ахуйн байцаагч, худалдаачид, тээвэрлэгч г.м.
 Борлуулалт	Үзэсгэлэн худалдаа зохион байгуулагч, супермаркет, лангуу эзэмшигч, худалдаачин, экспортлогч, МҮХАҮТ г.м.
 Хэрэглээ	Танай зөгийн балыг хүнсэндээ болон бусад бэлэглэхээр худалдан авдаг дотоод, гадаадын хүмүүс

Мөн дээрх хүмүүсээс гадна жишээлбэл шаардлагатай үед зөвлөж туслах орон нутгийн захиргааны хүмүүс, хачигтай тэмцэхэд зааварчлах мэргэжилтэн, санхүүгийн дэмжлэг үзүүлэгч, зөгийн аж ахуй болон зөгийн бал бүтээгдэхүүнтэй холбогдох журам заавар боловсруулах мөн хэрэгжүүлэх төр захиргааны байгууллага зэрэг талууд танай үйл ажиллагаанд оролцож байдаг.

Жишээ: Хэрэв таныг олон салбар бүхий зэрэглэл өндөртэй супермаркетад борлуулалт хийхээр хандахад тэндээс салбар 50 дэлгүүр бүрт рапсын балыг 180 гр, 350 гр-аар тус бүр 40 ширхгийг 5-10 дугаар сарын хооронд сар бүр нийлүүлэх шаардлага тавибал та яах вэ?

Супермаркетууд ихэвчлэн бүтэн жилээр борлуулалтын төлөвлөгөө гаргадаг. Сүлжээ дэлгүүрийн бүх салбарт төрөл бүрийн бүтээгдэхүүн байнга байх нь чухал байдаг. Ийм хүсэлт ирэх нь энгийн асуудал юм. Энэ тохиолдолд танд нэг жилийн борлуулалтанд 6 тонноос их зөгийн бал үйлдвэрлэх шаардлага үүсэж байна.

Мөн гадаад дахь зөгийн бал үйлдвэрлэгчээс Монголын зэрлэг цэцэгсийн гаралтай зөгийн бал 20 тонныг авахыг хүсвэл яах вэ?


Эсвэл өндөр зэрэглэлийн зочид буудлаас маш бага хэмжээтэй шилэнд савлагдсан цайвар тунгалаг өнгөтэй, байгалийн сэнгэсэн зөөлөн үнэртэй бал хүсэж байгаа бөгөөд түүнийг үнэт эдлэлийн сав мэт тансаг хайрцагтайгаар бэлтгээд өгөөч гэвэл та яах вэ?

Энэ бол боломжгүй зүйл гэж та эхнээсээ л бууж өгдөг үү?

Гэхдээ зөгийн балаа тус супермаркетад хоёулаа хамтраад нийлүүлэх найз зөгийчин байхыг үгүйсгэхгүй.

Мөн тухайн орон нутгийн зөгийчид байгалийн цэцэгсийн гаралтай балаа нэгтгэвэл 20 тн болж магадгүй шүү дээ. Бас шил импортлогч танил чинь танд яг тохирсон шил санал болгож магадгүй.

Төрийн болон судалгаа шинжилгээний байгууллагуудаас бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах механизмыг бий болгож зөгийчдийг дэмждэг байж болох юм.



15-2. Хамтрах аргаар ашгаа нэмэгдүүлэх

Ийнхүү зөгийн балны үйлдвэрлэлд оролцогч талууд ашгаа бага багаар нэмэрлэх байдлаар зөгийн балны эцсийн үнийг бий болгодог юм. Худалдан авагч эцсийн үнийг төлдөг ба үүнд үе шат бүрийн ашиг багтдаг.

Та зөгийгөө маш сайн арчилж маллаад, эрүүл ахуйн шаардлага хангасан сайхан амттай зөгийн бал бий болгодог боловч бүтээгдэхүүн бэлтгэх, борлуулах шатанд технологи зөрчих, чанарын шаардлага хангахгүй өөр бүтээгдэхүүнтэй холилдвол бүтээгдэхүүний үнэ цэнэ буурдаг.

Иймээс үйлдвэрлэлийн үе шат бүрийг хариуцагч нар хариуцсан үүргээ сайтар биелүүлж, бүтээгдэхүүний үнэ цэнийг дээшлүүлэхийн төлөө хичээвэл яаж байна?

Жишээлбэл: шаардлагад нийцсэн үүр хайрцаг, бүртгэл зөвшөөрөлтэй эм, өөрийн бүтээгдэхүүнд өнгө зүс оруулж сав боодол, эмийн зохистой эмчилгээ хийсэн зөгийн бүл, зөгий буулгагч хавтан ашиглаж бал ялгах үед зөгий үхэхээс сэргийлдэг, пестицидээр бохирлогдоогүй бэлчээр сонгодог, тохиромжтой балт ургамал, эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөл дэх савалгаа, нямбай тээвэрлэлт, худалдааны цэвэрхэн орчин, малын эмч болон байцаагчийн хяналт зэрэг нь чухал байдаг. Дээрх нөхцөлд үйлдвэрлэгдсэн тохиолдолд үнэ цэнэ өндөр болно.

Ийнхүү гинж мэт холбогдох үнэ цэнийн хэлхээг нэмүү өртгийн сүлжээ гэж хэлдэг. Нэмүү өртгийн сүлжээнд оролцогч бүрийн хүчин чармайлтаар гинжин хэлхээний үр ашиг нэмэгдэх буюу оролцогч бүрийн ашиг нэмэгддэг. Зах зээлийн хэрэгцээг хангахын тулд бусадтай баг болон ажиллах нь таны ашиг орлогыг нэмэгдүүлэх болно.

